



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 1.7%, 2023 онд: 4.9%
Инфляци: 2022 онд: 14.7%, 2023 онд: 11.6%

Урсгал тэнцэл: 2022 онд: -19.5%, 2023 онд: -16.8%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2022 оны тайланд прогнозын хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et> <https://bit.ly/2XR5XVj>

ДНБ-ий өсөлт: 2022 онд: 2.5%
Инфляци: 2022 онд: 14.8%

ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: -20.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.


Эх сурвалж: <https://bit.ly/3ax10Ra>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 11-р сарын байдлаар 1146.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 8 хувиар өссөн бол, зарлага 16 хувиар өсч төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1146.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.

Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 740 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**Ам.долларын ханш өмнөх сараас 36.53 төгрөгөөр өсжээ.**


Арваннэгдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 557.48 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 36.53 төгрөгөөр өсөж 3406.43 төгрөг болов. 11-р сард гадаад валютын нөөц 2.9 тэрбум ам.доллар буюу өнгөрсөн сараас 5.4 хувиар өсөж, оны эхнээс 32.8 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 29.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Инфляцын түвшин 14.5%**


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 11-р сарын байдлаар өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар, оны эхнээс 12.1 хувь өсөв. Үүнд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.8 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.5 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 19.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 16.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 21.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 7.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Гадаад худалдааны тэнцэл 3273 сая.ам долларын ашигтай гарав.**

2022 оны арваннэгдүгээр сард нийт барааны эргэлт 19 тэрбум ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 27 хувиар, экспорт 26 хувь, импорт өмнөх 27 хувиар тус тус өсөж гадаад худалдааны тэнцэл 3273 сая ам.долларын ашигтай гарав.



11-Р САРЫН ОНЦЛОХ: ГАДААД ӨР

Эх сурвалж: www.mongolbank.mn

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2022 оны 3-р улирлын байдлаар 32.45 тэрбум ам.доллар байна. Үүнийг бүтцээр нь задалвал Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн хэмжээ 24% буюу 7.6 тэрбум ам.доллар байгаа нь өмнөх улирлаас 443 сая ам.доллараар буурсан байна.

Нийт гадаад өрийн

- 12.3 (37.8%) тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг,
- 8.9 (27.3%) тэрбум ам.доллар нь бусад салбарынх,
- 7.6 (23.5%) тэрбум ам.доллар нь Засгийн газрынх,
- 2.3 (7.1%) тэрбум ам.доллар нь Төв банкных,
- 1.4 (4.2%) тэрбум ам.доллар нь Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх байна.

САРЫН ОНЦЛОХ

ХАДГАЛАМЖ

- Нийт хадгаламж 17 их наяд төгрөг болж өмнөх сараас 82 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 9.3 хувиар буюу 1.7 их наяд төгрөгөөр буурав.
- Төгрөгийн хадгаламж 12,3 их наяд төгрөг буюу өмнөх сараас 1.2 хувиар буурав.
- Валютын хадгаламж 4.7 их наяд төгрөг болж өмнөх сараас 1.5 хувиар нэмэгдэв.
- Өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 17 хувиар буурсан бол валютын хадгаламж 20 хувиар нэмэгджээ.
- Нийт хадгаламжийн 72 хувь төгрөгийн, 28 хувийг валютын хадгаламж эзэлж байна.

ЗЭЭЛ

- ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сараас 0.6 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 12 хувиар өсч 22.6 их наяд төгрөг болов.
- Чанаргүй зээлийн хэмжээ 2.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 10.9 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 4.9 хувиар өссөн байна.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 10.4% байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 11-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 11-р сар 2022 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn